

Golomt Capital®

Валютын зах зээлийн ТОЙМ

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК- Д БЭЛТГЭВ

2022.07.04

*Дотоодын зах зээл
Олон улсын зах зээл*

ДОТООДЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН СУУРЬ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2022 он 07 сарын 04

Ханшийн өөрчлөлт	Албан ханш	Долоо хоног	Оны эхнээс	Жил
	3,137.00	0.167%	10.109%	10.113%

Товч дүгнэлт:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш төгрөгийн эсрэг 0.167 хувиар чангарлаа. Төв банк оны эхний 4 сард интервенцийн хэмжээг нэмэгдүүлээд байсан бол 5, 6 сараас эхлэн бууруулж байна. Тодруулбал 2022 оны эхний дөрвөн сард сар бүр дунджаар 560-680 сая ам.долларын интервенц хийж ирсэн бол 5 сард 388 сая 6 сард 374 сая ам.долларын интервенц хийжээ.

Монголбанкны дуудлага худалдаа:

Өнгөрсөн долоо хоногт Монголбанк банкнуудын 134 сая ам.доллар худалдан авах хүсэлтийг зах зээлд нэг ханшаар нийлүүлсэн байна. Харин банкууд 5 сая ам.доллартай тэнцэх төгрөгийн форвард хэлцэл байгуулах санал ирүүлсэн боловч саналыг биелүүлээгүй байна.

**Гадаад худалдаа:**

2022 оны эхний 5 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны эргэц өмнөх оноос 21.9 хувиар өсч 7221 сая ам.долларт хүрсэн бол экспорт 22 хувиар өсөж 4083 сая ам.доллар импорт 20 хувиар өсч 3137 сая ам.долларт хүрсэн байна. Ингэснээр 2022 оны эхний 5 сарын байдлаар цэвэр экспорт 947 сая ам.доллар хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31 хувиар өссөн байна.



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2022 оны 7-р сарын 04

	Хаалтын ханш	7 хоног	1 сар	1 жил
DXY	104.82	1.10%	1.49%	13.43%
EURUSD	1.0435	-1.39%	-2.63%	-12.01%
USDCNY	6.6957	0.11%	0.55%	3.63%
USDRUB	54.5	2.09%	-10.58%	-25.82%
USDJPY	135.01	-0.31%	3.17%	21.67%
AUDUSD	0.6814	-1.65%	-5.51%	-9.56%

DXY ханшийн хөдөлгөөн:

Өнгөрсөн долоо хоногт ам.долларын ханш олон улсын зах зээл дээр голлох валютуудын эсрэг чангарах хөдөлгөөн үзүүлээ. Ханшийн өөрчлөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөллөө.

- Өнгөрсөн долоо хоногийн лхагва гарагт АНУ-ын төв банкны тэргүүр Jerome Powell инфляцын нөхцөл байдлын талаар мэдэгдэл хийсэн. Тэрээр мөнгөний чанга бодлогыг үргэлжлүүлж эдийн засгийн удаашралыг цаашид хөшүүрэгдээд ч болов инфляцын түвшинг буулгаж авна хэмээн мэдэгдсэн. АНУ-ын төв банк инфляцыг 2 хувьд хүргэж бууруулах зорилт тавиад байгаа бөгөөд энэ оны төгсгөл гэхэд бодлогын хүү 3.4 хувьд хүрэх төлөвтэй байгаа. Төв банк бодлогын хүүг удаа дараа өсгөж мөнгөний чанга бодлого баримталж байгаа нь ам.долларын ханшийг бусад валютын эсрэг чангарах хөшүүрэг болсоор байна.
- Энэ долоо хоногийн баасан гарагт АНУ-ын ажилгүйдлийн төвшин болон ажил эрхлэлтийн тоон мэдээлэл гарна. Тус тоон мэдээллээс үүдэн холбооны нөөцийн сан бодлогын хүүгээ дараачийн уулзалтаар хэдэн хувиар нэмэхээ шийднэ.

График 3 : DXY /ам.долларын индекс/-ийн 7 хоногийн лаа

Published on Investing.com, 4-Jul-2022 - 2:26:55 GMT, Powered by TradingView.
US Dollar Index Futures, (CFD) DX, D



Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.